



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 248

Улаанбаатар хот

“Түшиг Уул” ХК-ийн үнэт
цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 51, 62.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Түшиг Уул” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 434,577 /дөрвөн зуун гучин дөрвөн мянга таван зуун далан долоо/ ширхэг хувьцааг нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 4,345,770 / дөрвөн сая гурван зуун дөчин таван мянга долоон зуун дал/ ширхэг энгийн хувьцаанд хувааж, тус компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, Хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.
2. “Түшиг Уул” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000257